



Антибиотик гэж юу вэ?

Торол бүрийн нянгаар үүсгэгдсэн овчнийг эмчлэхэд хэрэглэдэг нян устгах үйлдэлтэй эмийн бэлдмэл. Харин вирусээр үүсгэгдсэн жирийн ханиад томуу болон суулгалтыг эдгээдэггүй.

Антибиотикийг эмийн сангаас зовхон жороор авч хэрэглэх ёстой.

Антибиотикийг жороор хэрэглэхийн ач холбогдол:

- Эмч таны овчинд тохирох антибиотикийг сонгож огно.
- Ямар тунгаар одорт хэдэн удаа, хэд хоног хэрэглэхийг зааж огно.
- Эмчийн зааврын дагуу хэрэглэснээр таны овчин бүрэн эдгэх болно.

Антибиотикийг буруу хэрэглэвэл:

- Хэрэглэх заалтгүй овчний вед хэрэглэвэл:
- Овчний шинж тэмдэгийг бүдэгрүүлж, оношлоход товогтэй болдог.
- Овчин архагшина.
- Тунг хэтрүүлэн хэрэглэвэл:

- Зовхон овчин үүсгэгч нянг устгаад зогсохгүй, хvний биед ашигтай бусад нянгуудыг устгаж моогонцор, вирус зэрэг бичил биетэн үржих боломжийг бүрдүүлдэг.

- Заасан хугацааны туршид гүйцэд хэрэглэхгүй овчний зовиур арилмагц хэрэглэхээ боливол:

- Эмчилгээ дутуу хийгдэнэ.
- Овчин үүсгэгч нян дасан зохицож, тухайн антибиотикт дасалтай болдог.

Антибиотикийн дасал гэж юу вэ?

Антибиотикийг бага тунгаар удаан хугацаагаар эсвэл эмчилгээний үргэлжлэх хугацааны турш бүрэн хэрэглэхгүй дутуу орхисноос антибиотикийн дасал үүсдэг.

Антибиотикийг эмчийн зааваргүй, оороо дур мэдэн буруу хэрэглэх нь антибиотикийн дасалтай болох гол шалтгаан болдог.

Хэрвээ ямар нэг антибиотикт дасалтай болсон бол танд зовхон тэр антибиотик тодийгүй түүнтэй адил үйлдэлтэй бусад антибиотик ч үйлчлэхгүй болох аюултай.

Антибиотикийг зов хэрэглэхийн тулд:

- Антибиотикийн мэдрэг чанарыг үзүүлж, оорт тохирох антибиотикийг хэрэглэх
- Антибиотикийг зовхон нянгаар үүсгэгдсэн халдварт овчний үед эмч зовлосон тохиолдолд хэрэглэх
- Антибиотикийг эмчийн заасан тунгаар зовлосон хугацааны турш гүйцэд хэрэглэх
- Ихэнхи антибиотикийг хооллохоос 30-60 минутын өмнө хэрэглэдэг боловч заримыг нь хоолны дараа хэрэглэдэг тул тухайн эмийн заавраас харж зов хэрэглэх

Антибиотикийг хэрэглэхэд анхаарах зүйл:

- Хэрвээ ямар нэгэн антибиотик танд таардаггүй бол эмчид үзүүлэхдээ заавал хэлээрэй.
- Тухайн антибиотикийг уух боломжтой вед хэзээ ч тариагаар бvv хэрэглээрэй. Зовхон шаардлагатай вед л тариагаар хэрэглээрэй.
- Антибиотикийг ялангуяа хvvхэд, жирэмсэн эмэгтэй, хохvvл эхэд маш болгоомжтой хэрэглээрэй. Учир нь тетрациклин, левомецетин зэрэг антибиотик нь хvvхэд болон урагт хортой нолоо үзvvлдэг.
- Хэрвээ антибиотик хэрэглэмэгц арьс улайж тууралт гарах, загатнах, амьсгал давчдах, болон харшлын ямар нэг шинж илэрвэл, хэрэглэхээ зогсоож эмчдээ даруй мэдэгдээрэй.
- Хvvхдийн гар хvрэхээргүй газарт, эмийн хайрцаг дээр заасан нохцолд хадгалаарай.
- Хугацаа дууссан бол бvv хэрэглээрэй.